

АТАР-ӨРГӨӨ ХК-НИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 4 дүгээр сарын 29

Дугаар 01

Улаанбаатар хот

Хурал 2022 оны 04 сарын 29-ны өдрийн 09.00 цагт “Атар-өргөө” ХК-ны үйлдвэрийн байрны 2-р давхарын хурлын танхимд ирц бүртгэсэнээр эхлэв.

ХУРАЛД ОРОЛЦСОН НЬ:

Атар-Өргөө ХК-ны хувьцаа эзэмшигчидийг төлөөлж Б. Мөнхдалай, Г. Энхболд, Г. Баттулга, Д. Алтансүх, Стандарт инвестмент ХХК /Батноров, Туул нарыг төлөөлж/, ТУЗ-ийн гишүүд Бямбахорлоо, Жигмэддагва, Болормаа, гүйцэтгэх удирдлагаас гүйцэтгэх захирал Сайнбилэг, дэд захирал Байгаль, санхүү эрхэлсэн захирал Отгондулам, эдийн засагч Гантуул, тооллогын комиссын гишүүд Энхтүвшин, Оюун-Эрдэнэ, Мөнхцэцэг, хурлын нарийн бичиг Баярмаа зэрэг нийт 18 хүний бүрэлдэхүүнтэйгээр оролцов.

Хурлыг ТУЗ-ийн дарга Ө. Мөнхдалай даргалж, хурлын нарийн бичгээр С. Баярмаа тус тус ажиллав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хурлын дарга Б. Мөнхдалай хуралд оролцогсодод мэндчилгээ дэвшүүлээд, саналын эрхийн бүртгэл, хурлын ирцийн талаар танилцуулахыг Тооллогын комиссын даргыг мэдээлэл өгөхийг хүсэв.

Тоологын комиссын дарга Ц. Энхтүвшин: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Атар-Өргөө ХК-ний ээлжит хуралд 174,136 ширхэг буюу 1,567,224 саналын эрх бүхий энгийн хувьцаа эзэмшдэг 347 хувьцаа эзэмшигч оролцохоос 88,056 ширхэг буюу 792,504 саналын эрхтэй 7 хувьцаа эзэмшигч өөрийн биеэр буюу итгэмжлэлээр оролцож ирц 50,56 хувь болсон тул Компаний тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69,1, Компаний дүрмийн 7,4 дэх заалтуудыг үндэслэн энэхүү хурлын ирц, хурлыг хүчин төгөлдөр гэж үзээд хурлыг эхлүүлэхийг зөвшөөрч байна. Тоологын комиссын тогтоолыг хавсаргаж байна.

Хурлын дарга Б. Мөнхдалай: За тэгвэл ирц маань хүрч, хурал хүчин төгөлдөр болж байгаа тул хурлаа эхлүүлэе. Хурлаар бид дараах асуудлуудыг хэлэлцэнэ:

- Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах

- Компанийн 2021 оны жилийн санхүүгийн тайланд ээлжит аудит хийсэн аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах
- Ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах
- Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөө
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, цалин, урамшууллын хэмжээг тогтоож, дотоод ажлын зардлын төсвийг батлах

1. Төлөөлөн удирдах зөвлөл Атар-Өргөө ХК-ийн 2021 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, Санхүүгийн 2021 оны тайлан, Атар-Өргөө ХК, түүний алба, нэгж, Гүйцэтгэх удирдлага 2021 онд 9,4 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, 193,8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Компани, түүний гүйцэтгэх удирдагч төлөвлөгөө, төлөвлөлттэйгөөр үйл ажиллагаагаа зохин байгуулж, эдийн засгийн амаргүй орчинд зах зээлийнхээ эзлэх байр сууриа хадгалж авч үлдэх, шинэ бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг татах, 2021 онд өмнөх жилүүдэд нэвтрүүлсэн Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 олон улсын стандартыг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажилласан байна.

Төлөөлөн удирдах зөвлөл Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Гүйцэтгэх удирдлагаас гаргасан тайлантай танилцаад дараах дүгнэлт гаргасан байна. Үүнд:

“Атар-Өргөө” ХК-нь:

1. Дотоод, хяналт шалгалтыг сайжруулах замаар үйлдвэрлэлийн өгөөж, ажил үүргийн хуваарийг нэмэгдүүлсэн.
2. Өмч, хөрөнгө, бэлэн болон бэлэн бус мөнгөн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтайгаар үйлдвэрлэлд ашиглахад анхаарч ажилласан.
3. Эрсдэлд суурилсан бодлогын бичиг баримтыг шинэчлэн батласан.
4. Өөрийн хөрөнгөөр шинэ тоног төхөөрөмжүүдээр үйл ажиллагаагаа сайжруулсан, хөрөнгө оруулалтыг зээлээр биш өөрийн хөрөнгөөр шийдвэрлэж, үйлдвэрлэлд шаардлагатай засвар үйлчилгээг цаг тухайд хийж гүйцэтгэсэн байна.
5. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг сахин хамгаалж зөрчилгүй ажиллаж чадсан.
6. Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж ажилласан.
7. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн, үйлдвэрлэлийн өгөөжийг нэмэгдүүлж ажилласан байна.

Энэ талаар гүйцэтгэх захирлаас Төлөөн удирдах зөвлөлд танилцуулж байгаа үйл ажиллагааны тайланд тусгагдсан бөгөөд үйл ажиллагааны үр дүнг тайландаа бүрэн зөв тусгасан байна гэж үзэж, гүйцэтгэх захирал чиг үүргээ хангалттай сайн биелүүлсэн гэж үзэж байна.

2. Мөн түүнчлэн жил бүрийн бизнесийн төлөвлөгөө бүрэн биелэхгүй байгаад дүгнэлт хийж бизнес төлөвлөгөөг үндэслэл сайтай биелэгдэхгүйц байдлаар боловсруулах шаардлагатай гэж үзэв.

Атар-Өргөө ХК-ийн 2021 оны үйл ажиллагаа, борлуулалтын орлого, үйлдвэрлэлийн зардлын харьцааг харгалзан үзэж компанийн цэвэр ашгийн тоон үзүүлэлтийг харгалзан компанийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн болно.

Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгөх дүгнэлтийг батлах саналыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж байна.

3. Төлөөлөн удирдах зөвлөл 2022 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн хурлын шийдвэрээр Атар-Өргөө ХК нь 2022 онд ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн.

Учир нь Дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар тахлын нөлөөлөл, цар тахлын эсрэг Төрөөс авч хэрэгжүүлсэн удаа дараагийн арга хэмжээнээс шалтгаалж Атар-Өргөө ХК-ийн үйлдвэрлэлийн хэмжээ буурсан, үйл ажиллагаа тодорхой түвшинд хумигдсан зэрэг хүчин зүйлээс шалтгаалж 2021 оны үйл ажиллагааны цэвэр ашгийг компанийн үйл ажиллагаанд зарцуулах нь зүйтэй гэж компанийн Төлөөлөн удирдах зөвлөл үзсэн болно.

Ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 19-ны өдрийн 03 дүгээр тогтоолыг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг зөвшөөрч өгөх саналыг оруулж байна.

4. Компанийн тухай хуульд зааснаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хийх өдрөөр дуусгавар болох, одоо мөрдөж байгаа Компанийн дүрмээр төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдийн тоог ес, үүнээс хараат бус гишүүний тоог гурав байхаар тогтоосон.

Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хороо дор дурдсан хүмүүсийг Төлөөлөн удирдах зөвлөлд сонгогдох нэрийн жагсаалтад тус тус бүртгэн авч, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэрийг нь дэвшүүлсэн тухай шийдвэр гаргасан болно. Та бүхний өмнө нэр дэвшигчдийн таницуулга байгаа болно. Танилцан саналаа өгөөрэй.

5. За одоо уламжлал ёсоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоож, зардал батлах тухай хэлэлцэе. Мөн та бүхний өмнөх танилцуулга дээр хавсралтаар очсон байгаатай танилцан саналаа өгнө үү.

За ингээд та бүхэн эдгээр асуудлуудаар санал бодлоо 15 минут хугацаанд санал бодлоо хэлэлцэе.

Гишүүд саналаа хэлэлцээд саналын хуудсаа бөглөв.

Тооллогын комисс хуралдаж дүнг дарга Ц. Энхтүвшин танилцуулав: Атар-Өргөө ХК-ны 2022 оны 04 сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд өөрийн биеэр болон итгэмжлэлээр оролцсон хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар өгсөн саналын эрхийг тоолсон тооллогын дүнгээр дараах байдлаар санал өгсөн байна.

- Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, компанийн 2022 оны бизнес хэлэлцэж батлах-99,9% зөвшөөрсөн
- Компанийн 2021 оны жилийн санхүүгийн тайланд ээлжит аудит хийсэн аудитын байгууллагын дүгнэлт- 99,9% зөвшөөрсөн
- Ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр-99,9% зөвшөөрсөн
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, цалин, урамшууллын хэмжээг тогтоож, дотоод ажлын зардлын төсвийг батлах -99,9% зөвшөөрсөн

Хурлаар хэлэлцэх асуудал 10:30 цагт дуусч хурал хаасныг мэдэгдэв.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн :

Хурлын нарийн бичгийн дарга

С. Баярмаа

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

ХУРЛЫН ДАРГА

Б. МӨНХДАЛАЙ

